

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
2020 НД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОВЧОО**

ЗОРИЛТ	Сумын ЗДҮАХ- ийн арга хэмжээний тоо	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	100	70	40	0	ҮБ	Хувь
НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД	4	4	2	2	-	-	-	85.0
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД	4	4	3	1	-	-	-	92.5
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД	3	7	1	4	1	-	1	70.0
ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД	2	9	4	5	-	-	-	83.30
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД	2	5	1	3	-	-	1	77.5
ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД	1	10	4	3	1	1	1	81.25
Дүн	16	39	15	18	2	1	3	81.59

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
2020 НД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2020.12.18

№	Зорилт	Арга хэмжээ	2020 он Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД					
Зорилго: Төрийн үйлчилгээг зөв зохион байгуулан, хариуцлагатай, чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, нээлттэй, ил тод байдлыг ханган, хуулийг хэрэгжүүлэн ажиллана.					
1	1.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	1.1.1. Төрийн албан хаагчдыг чадваржуулах ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, ил тод хүртээмжтэй хүргэнэ.	- Төрийн албан хаагчдыг сургалтанд хамруулах, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах - Иргэдийн гомдолгүй ажиллах	Сумын сургууль, цэцэрлэгийн удирдлагууд болон багш нар нийслэл болон бусад аймгуудын сургууль, цэцэрлэгтэй харилцан туршлага солилцох арга хэмжээнд 206 албан хаагч хамрагдлаа. Тухайлбал: Сургуулийн сургалтын 13 менежер Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймгийн ЕБС-иудын үйл ажиллагаатай танилцан, цэцэрлэгийн 184 багш, ажилчид Улаанбаатар хотын 5, “Сүзүрин цэцэрлэг, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймаг, Дэлгэрхангай сумын цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцлаа. ЗДТГазрын 25 албан хаагч Өмнөговь аймгийн Даланзадгад хотноо хотуудын холбооны 3 өдрийн сургалтанд хамрагдлаа. Төрийн үйлчилгээний талаар иргэдээс гомдолгүй ажиллалаа.	100
2	1.2. Хууль ёсыг бэхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ	1.2.1. Иргэдийн оролцоотой Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүх шатанд авлигаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй ил тод байдлыг хангана.	Иргэдэд мэдээлэл хүргэх, албан тушаалтны ХАСХОМэдүүлгийг цахимд байршуулна. Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМэдүүлгийг бүрэн хянуулж, ашиг сонирхлын зөрчилгүй томилгоог хэвшүүлнэ.	Энэ онд ЕБСургуулийн сургалтын менежер 4, сургуулийн захирал 1, цэцэрлэгийн эрхлэгч 1, багийн засаг дарга 5, нийт 11 албан тушаалтны ХАСУМ-ийг цахимаар хянуулан, хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг гаргууллаа. Ажлын байрны томилгооны зөрчилгүй ажиллаж, ХАСХОМ гаргагч нар 2019 оны мэдүүлгээ хуулийн хугацаанд цахимаар гаргалаа. “Би авилга өгөхгүй авахгүй” арга хэмжээг зохион байгуулж, энгэрийн тэмдгийг мэргэжилтнүүдэд олголоо.	100

3	1.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	1.3.3.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийг үүрэг хариуцлагыг сайжруулна.	- Хүүхдийн дунд гарах зөрчлийг бууруулж,эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлнэ. - Тэдэнд тавих хяналтыг сайжруулахад багш, нийгмийн ажилтнуудыг үүрэгжүүлнэ.	Сумын “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа” цахим аяны хүрээнд Оюуны гэгээ ТББ-тай хамтран туршилтын 18 өрхөөр айлчилж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, гэр бүл төлөвлөлтийн талаар сурталчилан таниулж, гарын авлага бэлтгэн 18 өрхийн 34 насанд хүрэгчдэд тараалаа. Ахуйн архидалт ихтэй 2 өрхөөр айлчилж эцэг эх асран хамгаалагчид болон хүүхдүүдтэй ганцаарчилсан уулзалт ярилцлагыг зохион байгуулж, ГХЗУСэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өглөө. Гэрээр айлчлал хийх үед болон сургууль, цэцэрлэгээс зохион байгуулсан сургалтуудад эцэг эхчүүдийг хамрууллаа.	70
4	1.4.Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх	1.4.1.Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэдэд сурталчилан хэрэгжүүлж,хяналт тавина.	Цэрэг татлага,цэргийн бүртгэлийг хуулийн хугацаанд зохион явуулах, иргэдийг бүрэн хамруулна. Төрийн байгууллагуудад батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг шалгана.	2020 оны 2 ээлжийн цэрэг татлагыг зохион байгууллаа. Цэргийн алба хаах насны 398 иргэн хамрагдаж, 46 нь цэргийн албанд тэнцлээ. Цэрэг татлагын товчоогоор орсон иргэдийн 60% нь өвчнөөр тэнцэхгүй байна. Сум өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт өвчнөөр хасагдсан иргэдийн нэрийг хүргүүлж,эрүүлжүүлэх үүрэг өглөө. Тус сумын хувьд цэргийн насны иргэд бүрэн дундаас дээш боловсролтой байна.	70
Хэрэгжилт-85.0%					
ХОЁР . ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД					
Зорилго:Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, “Шилэн данс”ны хуулийг бүх шатанд хэрэгжүүлнэ.					
1	2.1.Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх	2.1.2.Газар ашиглалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулна.	Газрыг дуудлага худалдаанд оруудах зарыг тухай бүр нийтэд мэдллийн төрөл бүрийн сувгаар хүргэнэ.	2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 12 байршил тусгагдснаас сумын хэмжээнд 9 дуудлага худалдааг цахим бирж /www.mle.mn/ системээр зарлаж, 7 дуудлага худалдаанд оролцогч бүртгүүлээгүй, 1 дуудлага худалдаанд ялсан иргэнтэй гэрээ байгуулж, орон нутгийн төсөвт 5 сая төгрөгийг төвлөрүүллээ. 1 дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулаад байна.	70
2	2.2 Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах	2.2.1.Төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн, өр авлагагүй ажиллана.	Сумын статистик мэдээ, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.	Сумын статистик мэдээг багийн засаг дарга,болон холбогдох мэргэжилтнүүдээс авч,хуулийн хугацаанд гаргалаа. Санхүүгийн тайланг цахим, самбараар иргэдэд мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг хангалаа. Өнгөрсөн онд сумаараа санхүүгийн зөрчилгүй дүгнэлт авлаа.	100

	2.2.3. Байгууллага бүрийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, төсвийн шууд захирагч, нягтлан бодогчдын ажлын хариуцлагыг сайжруулна.	Төсвийн шууд захирагч нарын хамтын гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг үзүүлэлт болгон тусгах, ня-бо нарын ажлын үр дүнг тооцно	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн мэдээллээ төсвийн байгууллага бүр хуулийн хугацаанд хийлээ. ЗДТГ-ын цахимд санхүүгийн мэдээллийг тухай бүр байршууллаа. Удирдлагуудын хамтын гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг дүгнэж, зөрчилгүй ажиллалаа. Өмнөх оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийгдэж хангалттай үнэлэгдлээ.	100
	2.2.4. Татварын орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэхэд төрийн албан хаагчдын ажлын уялдаа, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх үүргийг албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тусгах, сарын аян зохион байгуулна.	Сумын засаг даргын А/22 тоот захирамжаар хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлын хэсэг ажиллалаа. Аяны хүрээнд 110 гаруй ААН-г, төсөвт байгууллагатай гэрээ байгуулж, хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 73.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 66.3 сая төгрөг төвлөрүүлж хэрэгжилт 90.8 хувьтай байна	100

Хэрэгжилт-92.5%

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, ажиллаж амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгох замаар хүний хөгжлийг дээдэлнэ.

1	3.1. Эрүүл мэнд	3.1.1. Иргэдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулж, В,С вирусийн илрүүлэлт, эмчилгээг сайжруулж, зонхилон тохиолдох хавдрын өвчлөлийг бууруулна.	- Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааг өнгөрсөн оноос 10 хувиар нэмэгдүүлнэ.	Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 479 албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 241 албан хаагч өвчлөлтэй гарч, давтан үзлэг шинжилгээнд хамруулж, гэрээр болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлж 8.9 сая төгрөг зарцууллаа. ЭМСайд, БШУС-ын удирдамжаар боловсролын байгууллагуудын 527 багш, ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдлаа. Эрүүл мэндийн төрөл бүрийн мэдээлэл зөвлөгөө, гарын авлагыг 4150, 8 төрлийн сургалтанд 3412 албан хаагч, иргэд хамрагдлаа. Эрүүл амьдрах энгийн алхамууд сургалтыг 17 байгууллагын 724, Ковид-19, АЗДХӨ-өөс сэргийлэх сургалт-350 гаруй иргэдэд зохион байгууллаа.	70
		3.1.8. Иргэдийн усыг зохистой хэрэглэх, ашиглах боломжийг бүрэн шийдвэрлэх арга хэмжээ авч гадаадын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг	- Иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, ундны усны эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарна.	Зориулалтын бус хуванцар савны уриалга, зөвлөмжийг 18 худаг дээр байршуулж, 383 иргэнд гарын авлага тараалаа. Төвийн 5 багийн 3729 өрхөөс 1279 өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон бөгөөд бусад 2450 өрхөөс зориулалтын эко сав болон төмөр саваар ус зөөдөг 757, зориулалтын бус хуванцар саваар ус зөөдөг 920 өрх	70

		судална.		байна. Ундны усаа зөөж тээвэрлээд төмөр болон зориулалтын эко саванд хадгалдаг 939, зориулалтын бус хуванцар саванд 751 өрх ус хадгалж хэрэглэж байгаа судалгаа гарлаа. Үүнээс харахад нийт өрхийн 32,1 % нь зориулалтын эко саваар ус зөөдөг, 38,3% нь зориулалтын эко саванд ундны усаа хадгалж байна. Эко сав-Элэг бүтэн амьдрал уриалгыг цахимаар иргэдэд хүргэлээ. Номгон-рашаан ХХК, Өнөмөнх хайрхан ХХК, 1998 зэрэг худалдааны төвүүдэд Эко сав худалдаалж хамтран ажиллах засаг даргын албан тоотыг хүргүүллээ. Сумын ЭМТөв иргэдэд хуванцар савны хэрэглээ түүний таних тэмдэгийг зөв унших, амьдрал ахуйдаа чанарын шаардлага хангасан савыг хэрэглэж сургах зорилгоор цахим хуудсаар 4 төрлийн мэдээлэл, хөдөөгийн 4 багийн малчдын тойролтоор ундны усны 7 дадал, хуванцар савны тэмдэг тэмдэглэгээний талаар 160 өрхөд хүргэлээ.	
		3.1.12. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувийг сумын хэмжээнд нэмэгдүүлэхэд хамтарсан багийн үйл ажиллагааг дээшлүүлнэ.	- Багийн засаг дарга, нийгмийн ажилтан, сум, өрхийн ЭМТөвийн хамтын ажиллагааг сайжруулан иргэдийг үзлэгт бүрэн хамруулах арга хэмжээг зохион байгуулна.	Багийн засаг дарга нартай хамтран судалгаа гарган хэрэгжүүллээ. Элэгний В, С шинжилгээнд-1202 иргэнийг хамруулж, 15% буюу anti-HCV эерэг -50, HBsAg эерэг-42 гарлаа. Артерийн гипертенз илрүүлгийн үзлэгт 1473 буюу 50%, чихрийн шижин хэв шинж 2-т 1380 иргэн буюу 45%, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 1464 буюу 42%, умайн хүзүүний хавдар илрүүлэх PAP шинжилгээнд 644 эмэгтэй хамрагдаж 70,2%-тай байна.	70
2	3.4 Соёл, урлаг	3.4.3. Хүүхэд бүрийн авьяасыг нээн хөгжүүлэх зураг, техник технологийн хичээлийн тайланг эцэг эх, иргэдэд сурталчилна.	- Ажлын хэсгийг засаг даргын захирамжаар байгуулан төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	Сумын засаг даргын А/13 захирамжаар ажлын хэсэг байгуулагдан ажлын төлөвлөгөө, удирдамжийг сургуулиудад хүргүүллээ. Арга хэмжээ өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас хийгдээгүй.	40
3	3.6. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал	3.6.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.	- Үйлдвэрлэлийн ослыг бууруулж, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна.	Сумын ХАБЭА-ын зөвлөлийг засаг даргын А/99 захирамжаар 9 албан хаагч, иргэний бүрэлдэхүүнтэй байгуулагдлаа. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 23 байгууллага, аж ахуй нэгж ХАБЭА-ын зөвлөл байгууллаа. Төсөвт 15 байгууллага Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэдээллийн самбар ажиллуулж, гарын авлага, цахим видео бэлтгэн мэдээллээ. Мэргэжлийн байгууллагуудаас зохион	70

				байгуулагдсан 3 удаагийн сургалтанд 500 гаруй албан хаагчид хамрагдлаа.	
		3.6.2.Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийн бүртгэлийг төгөлдөржүүлж ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилж ажилгүйдлийг бууруулна	- Бүртгэлийг үндэслэн байнгын болон түр ажлын байранд зуучлагдсан иргэний тоог өмнөх оноос 10 % иар нэмэгдүүлнэ.	Шинээр ажлын байр хайж буй иргэдээс 71 иргэн LIMIS программд бүртгэлтэй байна. Байнгын ажлын байранд 41 иргэн, түр ажлын байранд 132 иргэн, улирлын ажилд 1 иргэнийг ажилд зуучиллаа. Ажилгүйдлийн түвшин өмнөх онтой харьцуулахад 0,6%-иар буурсан үзүүлэлттэй байна.	100
		3.6.4. Иргэдэд хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтуудыг оновчтой хэлбэрээр зохион байгуулж мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ	- ХХҮГазартай хамтран сургалтанд иргэдийг оролцуулна.	Өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас хийгдээгүй.	-
Хэрэгжилт -70.0%					
ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД					
Зорилго: Уламжлалт мал аж ахуйг фермерийн аж ахуйтай хослуулан хөгжүүлж,бизнес эрхлэгчдээ дэмжин, өрх бүрийн орлогыг нэмэгдүүлнэ.					
1	4.1.Мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх	4.1.1 “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	- Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ.	"Монгол мал" хөтөлбөрийг хэрэгжүүлэх 42 арга хэмжээ төлөвлөснөөс 30 нь хэрэгжлээ. ОНХС-ийн хөрөнгөөр 5 малчин өрхөд 391 толгой мал олгон, МХДХөтөлбөрөөр 2 залуу малчин өрхийг 9 сая төгрөгийн зээлд хамрууллаа. НҮБ-ын аж үйлдвэрийн байгууллага, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслийн хүрээнд хонины ноосны чанар сайжруулах олон улсын сургалтыг ХХААХҮЯам, аймгийн засаг дарга, сумын засаг дарга хамтран Далай багт 7 хоног зохион байгууллаа. Нутгийн шилмэл "Сайнцагаан" хонийг ШУ-ны үндэслэлтэй судлуулан “мах-өөх-ноос”-ны хосломол ашиг шимт малын омог болгон батлуулж, хээлтүүлэгчийг мал үржлийн нэгжид эзэмшүүлэн, үржилд ашиглаж байна.	100

	4.14 Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлнэ. СЗДҮАХ-4.1.4.	Ногоон алт – малын эрүүл мэнд төсөл"-ийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог сайжруулна. Хөдөөгийн багуудын бэлчээр ашиглагчдын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	Энэ онд бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сумын ИТХурлаар батлуулж,хэрэгжүүллээ. Наран багт-1, Тэвш багт-2, Далай багт-2 нийт 5 өрх бэлчээр хашлаа. Бэлчээрийг малчдын бүлэгт гэрээгээр ашиглуулахаар хөдөөгийн багуудын нэгдсэн хурлаар мэдээлэл хийж, Далай багийн ИНХ-аар хэлэлцүүлж, малчдын саналыг авч, гэрээний төсөл боловсрууллаа. Сумын ОНХС-ийн 16 сая төгрөгний санхүүжилтээр энгийн уурхайн 8 худгийг засварлалаа.	70
	4.1.14.Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг сайжруулж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	5 га-аас доошгүй талбайд бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавьжтай тэмцэх ажлыг энгийн механик болон микро биологийн аргаар малчдын оролцоотойгоор зохион байгуулна -Малыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг шинжилтгээ, тарилга,туулгад 70 аас дээш хувь хамруулна.	Хөдөөгийн 4 багийн 2 мянган га бэлчээрт микробиологийн аргаар 8 техник, 17 иргэн ажиллаж, 28501311.42 төгрөг, 2 багийн 5 мянган га бэлчээрт энгийн механик аргаар 6 техникийн аргаар устгах ажилд 11 иргэн ажиллаж 7999440 төгрөг зарцуулан 78-82.5%-ийн гүйцэтгэлтэй ажиллаа. амьтны өвчлөлийн 51 дуудлага хүлээн авч 33 дээжийг шинжлүүлэн дүгнэлт гаргууллаа. Бруцеллёзын шинжилгээнд буур-14, бух-68, хуц-1160, ухна-1015 бүгд 2257 хээлтүүлэгч хамруулахаас 4 буур, 11 бух, 760 хуц, 655 ухна нийт 1430 хээлтүүлэгч хамрагдаж 63% гүйцэтгэлтэй байна. Мал сүргийг халдварт болон гоц халдварт, халдваргүй, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт тэмээ-139, адуу-852, үхэр-15935, хонь-262390, ямаа-251787 нийт 531103 малыг хамруулж, төлөвлөгөөг 120.0%-тай биелүүллээ. Мал угаалганд үхэр-4164, хонь-193942, ямаа-205266 бүгд 403372 мал хамруулж 104,67%-ийн гүйцэтгэлтэй байна.. Хөдөөгийн 4 багт болон аймгийн төв орчим, засмал зам дагуу 569 км-т 821 үхсэн малын сэг зэмийг цуглуулж аймгийн төвлөрсөн хогийн цэгт булж ариутгал халдваргүйтгэлийг хийлээ.	100
	4.1.15.Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бруцеллёз өвчинтэй тэмцэх арга хэмжээгтогтмол зохион байгуулна.	Вакцинжуулалтанд 70.000 мал, шинжилгээнд 5.000 мал хамруулж, 50 мянгаас доошгүй малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийнэ. Малын хашаа хороо худаг усны орчмын 20.0	Бруцеллёзын дархлаажуулалтанд богийн охин төл 46275, 358 охин тугал нийт 46633 охин төл хамруулж 99,6%-тай байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 төрлийн дархлаажуулалт хийлээ. Үүнд: Шөвөг ярын дархлаажуулалтан 17291 ишиг хамруулж 83,77%, ДХХ-энтеробактериоз хамын дархлаажуулалтанд бог мал 42992 хамруулж, 80,09%, галзуугийн дархлаажуулалтанд 2415 мал хамруулж 84,41%, дуутын дархлаажуулалтанд 1187 үхэр хамруулж 107%, Сахуугийн дархлаажуулалтанд унага	100

2			доошгүй мкв талбайд ариутгал халдваргүйтгэл хийнэ. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, мал угаалгыг хийлгэнэ.	892 ыг хамруулж 100% гүйцэтгэлтэй ба нийт дүнгээр 64777 толгой малыг 93,6% хамрууллаа. Бруцеллёзын шинжилгээнд 275 хуц, 150 ухна нийт 425 хээлтүүлэгч хамрагдсанаас 7 хуц,3 ухна эерэг /өвчтэй/ гарсан тул зааврын дагуу арга хэмжээ авлаа. Мөн 32 өвөлжөө, 18 уст цэг, бэлчээрийн 11900 мкв талбайг ариутгалаа. 4 багт мал угаалгын суурин банныг шинээр байгууллаа.	
		4.1.17.Орон нутагт болон отрын бүсэд байгаа малчдын өвөлжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулна.	Тухайн оны өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх, шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулахад иргэд, малчдын оролцоог нэмэгдүүлж, хяналтыг зохион байгуулна.	2020-2021 оны мал өвөлжилт, хаваржилт, онд оролт 98%-тай, төл бойжилт 99.2%-тай, зуншлага тааруу байсан учир гаднын аймаг, сумын нутагт 251 малчин өрх отор нүүдэлтэй байна. Сумын өвсний нөөцөд одоогийн байдлаар 75.24 тн өвс, 5.7 тн үйлдвэрийн тэжээл нөөцлөөд байна.	70
	4.2Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдаа	4.2.3.Нийтийн хоол, зочид буудлын үйлчилгээний стандарт, шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавина.	Худалдаа үйлчилгээний стандартын дагуу үйлчилгээ үзүүлдэг байна.	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 22 газраас 17 газарт “Хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас”-аар үнэлгээ хийж, дундаж нь 88%-тай үнэлэгдлээ. Аймгийн МХГазартай хамтран 4 зоогийн газарт төлөвлөгөөт шалгалт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдлээ. Зочид буудлын үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Дэлгэрэх бүрд ХХК “Бүрд”, “Алтанговь”, Алтан цант ХХК “Говь”, Royal буудлуудын үйл ажиллагаанд МХГазар, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран хяналт шалгалтыг зохион байгууллаа.Хяналт шалгалтаар буудал бүрийг чанарын баталгаажуулалтын үнэлгээнд хамруулж, нийт үнэлгээний дундаж 80,3% үнэлэгдлээ.	70
		4.2.6.Үйлдвэрлэлээ өргөжүүлэн, бүтээгдэхүүнээ гадаад, дотоодын зах зээлд нийлүүлж байгаа үйлдвэрлэгчдийг дэмжинэ.	- Аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Үйлдвэрлэлээ амжилттай хөгжүүлж байгаа үйлдвэрлэгчдийг “Дундговьд үйлдвэрлэв” сэтгүүл, “Сайнцагаан-Сүүнцагаан” сонингоор дамжуулан олны хүртээл болгож байна.	70

		4.2.15.Иргэдийн санал санаачлага оролцоотойгоор шинээр 6 жижиг дунд үйлдвэр байгуулна	үйлдвэрүүд байгуулагдаж иргэдийн орлого нэмэгдэнэ.	Малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах бичил үйлдвэр 2, нэхий боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1, нарийн ногоо үйлдвэрлэх өвлийн хүлэмж 1, малын ногоон тэжээл үйлдвэрлэх үйлдвэрүүд шинээр бий боллоо.	70
		4.2.16.Үйлдвэрлэл,үйлчилгээ, нөхөрлөл, хоршоо, ЖДҮйлдвэрлэл байгуулах иргэдийн санаачлагыг дэмжин хөнгөлөлттэй зээл олгон, ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 0.2-оос доошгүй хувиар бууруулна	-Тэргүүлэх чиглэлээр зээл олгогдсон байна	Сумын тэргүүлэх чиглэлийн дагуу ЖДҮйлдвэр, үйлчилгээ эрхлэгч барилгын материал үйлдвэрлэлд 1 иргэнд 17 сая, ХАА, газар тариаланд 1 ААН, 7 иргэнд 199 ,0 сая, хөнгөн үйлдвэрт 2 ААН, 4 иргэнд 173,0 сая нийт 15 төсөлд 389,0 сая төгрөгийн зээлийг олголоо. Дээрх төрлийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд шинээр 49 ажлын байрыг бий болгосон нь өмнөх оноос 50 хувиар нэмэгдлээ.	100

Хэрэгжилт-83.3%

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД

Зорилго:Байгалийн нөөцийг зохистой ашиглаж,байгаль хамгаалах,нөхөн сэргээх,аялал жуулчлал,уул уурхайгаас орон нутагт орох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.

1	5.1.Байгаль орчныг хамгаалах	5.1.7.Байгаль орчныг хамгаалах хяналтын үр дүнг дээшлүүлэн, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Иргэдэд байгаль орчны талаарх сургалтыг зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас хийгдээгүй.	-
		5.1.8.Малчдын эзэмшиж байгаа өвөлжөө, хаваржааны доорх газрыг гэрчилгээжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	БИНХ-ын санал, малчдын хүсэлтийн дагуу малчдын эзэмшиж буй өвөлжөө хаваржааны доорх газрыг эзэмшүүлж гэрчилгээжүүлнэ.	2020 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын захирамжаар 51 малчинд 22.5 га газрыг өвөлжөө, хаваржааны доорх газрын зориулалтаар олголоо.	100

		5.1.9.Сумын газар зохион байгуулалтыг сайжруулж, иргэдийн хүсэлтийн дагуу иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлж, газар өмчилсөн иргэдийн тоог 2000- аар нэмэгдүүлнэ.	Монгол улсын Засгийн газраас 2020 онд Иргэнд зөвхөн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг нь өмчлүүлэхээр шийдвэрлэсэн тул энэ онд гэр бүлийн хэрэгцээний болон аж ахуйн зориулалтаар шинээр газар өмчлүүлээгүй. Эзэмшиж байгаа газраа өмчлөх хүсэлт ирүүлсэн 30 иргэнд 2.05 газрыг аймгийн Засаг даргын захирамжаар өмчлүүллээ.	70
		5.1.10 Иргэн аж ахуй нэгж байгууллагад газрыг эзэмшүүлж, эзэмшил газрын ашиглалтыг сайжруулна.	Иргэн ААНэгж байгууллагын хүсэлтийн дагуу газрыг эзэмшүүлж ашиглуулна. Газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нарт газрын төлбөр татварын ногдуулалтыг хийж, гүйцэтгэлд хяналт тавина.	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын захирамжаар 119 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 156,4 га газрыг эзэмшүүллээ. Мөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн 570 газарт газрын төлбөрийн ноогдуулалт үүсгэж, 60%-ийг төлүүллээ.	70
2	5.3.Ашигт малтмал, уул уурхайн хяналтыг сайжруулах	5.3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэнд тавих хяналтын үр дүнг дээшлүүлнэ.	13.Тусгай зөвшөөрөлтэй ААНэгж байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ	Эзэмшлийн гэрчилгээтэй 48 ААНэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ, менежментийн төлөвлөгөө хийлгэх албан шаардлага өгч 39 буюу 80 хувь нь хийсэн байна.	70
Хэрэгжилт-77.5%					
ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД					
Зорилго:Байгалийн нөөцийг зохистой ашиглаж,байгаль хамгаалах,нөхөн сэргээх,аялал жуулчлал,уул уурхайгаас орон нутагт орох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.					
1	6.2 Барилга, хот байгуулалтыг шинээр нэмэгдүүлж, тохижилтыг сайжруулах	6.2.1.Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгыг дуусгаж ашиглалтанд оруулна.	3500 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн ашиглалтанд орсноор спорт, соёл, урлагын нэгдсэн арга хэмжээ зохион баайгуулах нөхцөл боломж бүрдэнэ..	Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын ажлыг “Зуут констракшин” ХХК улсын төсвийн хөрөнгөөр хийж байна. ажлын явц 70% -тай байна.	70
		6.2.5.Сумын ЗДТГазрын барилгыг шинээр барина.	2 давхар 1008м ² төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон нутгийн захиргааны баригдаж улмаар төрийн	Хийгдээгүй	-

			үйлчилгээний орчин сайжирна		
		6.2.6.Зарим сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгад засвар хийнэ.	- Сургалтын орчин сайжирна.	БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар 4, 5-р цэцэрлэгийн барилгын дээврийг 60 сая төгрөгийн өртөгтэй засварын ажлыг “Бейс буйлдинг”, “Дөл” ХХК-иуд гүйцэтгэлээ.	100
		6.2.7 Зарим сургууль, цэцэрлэгийн гадна орчин, тоглоомын талбайг тохижуулна.	Тохижилт хийгдэж орчин нөхцөл сайжирна	Стандартын биеийн тамир, туршилт, элсний сүүдрэвчтэй талбай, хүлэмж, зүлэгний сав, хашаа, сандал, хог ангилах сав, авто зогсоол, байгууллагын хаягийг монгол бичгээр хийж байрлуулах зэрэг бүтээлч ажлуудыг хийж, гадна орчноо тохижуулахад 10,2 сая төгрөг зарцууллаа. ГИЦСургуулийн спорт тоглоомын талбайн тохижилтыг улсын төсвийн 178,19 сая төгрөгөөр “Мандал шилтгээн” ХХК гүйцэтгэлээ. ЭДЦСургуульд 1998 оны төгсөгчид сургуулийн гадна орчинд хүүхдийн тоглоом, нээлтийн индэр зэрэг 200 сая төгрөгийн бүтээн байгуулалт хийж, 100 мод тарилаа.	100
		6.2.8.Зохиомол биологийн цэвэрлэгээтэй бохир ус цэвэрлэх байгууламж ашиглалтанд оруулна.	Хоногт 3000м ³ хүчин чадалтай байгууламж бий болж бохир ус цэвэрлэх хүчин чадал нэмэгдэж стандартын дагуу цэвэрлэх нөхцөл бүрдэнэ.	Азийн хөгжлийн банкны 8,395,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандалговь хотын цэвэрлэх байгууламжийг “Сайн констракшин” ХХК, “Сан констракшин” ХХКомпаниуд гүйцэтгэж байна. явц 10%-тай байна.	40
		6.2.9. Айраг, Мандал багт 2,8 км хатуу хучилттай зам барина.	-Хотын замын нөхцөл, хүчин чадал сайжирна	Аймгийн төвийн 2,8 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг улсын төсвийн 2,176.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Дэвжих-Эрдэнэ" ХХКомпани гүйцэтгэж байна.хэ	70
		6.2.10 Замын сангийн хөрөнгөөр аймгийн төвд шинээр зам барих, засварлах, явган хүний зам талбай байгуулна	- Бүтээн байгуулалт хийгдсэнээр иргэдийн амьдрах орчин нөхцөл сайжирна.	“Эс Жи Эм” ХХК Аймгийн замын сангийн 38.225.000 төгрөгөөр Зам талбайн гэрэлтүүлэг засварын материал болох 100wt чадалтай лед гэрэлтүүлэгч 150ш, 4x16 сип кабель 2000м-ээр Айраг Мандал Нарлаг багийн гудамж талбайн гэрэлтүүлэгийн бүрэн засварлалаа. “Дэвших-Эрдэнэ” ХХК 142.647.569 төгрөгөөр аймгийн төвийн 5 гудамжинд 55,4 м3 асфальт цутгалт, 8м авто замын хашлага солих, 6ш хурд сааруулагч, 12ш босоо тэмдэг шинээр ажлыг хийлээ. ХТГазрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зам засварын хүйтэн асфальт 150 уут, цас мөс хайлуулах давс 20 тн, мөс цас хайлуулагч реагент бодис 87	70

				уут, шохой лагшин 3 тн, зам талбайн засварт ашиглагдах 442м урт төмөр, 4 өнгийн 2500л будаг, будаг шингэлэгч 300ш, өнхрүүш 680ш тус бүрийг “Туулант гол” ХХК 43.015.000 төгрөгөөр нийлүүллээ.	
		6.2.11.Гэр хорооллын гудамжнуудыг цэгцлэх, хөндлөн гарц гаргаж, хашааг жигдрүүлэх, тохижуулах арга хэмжээг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.	- Төвийн 5 багийн газар зохион байгуулалтын шаардлага хангагдана.	Хийгдээгүй	0
		6.2.12.”Гэрэлтэй Мандалговь”, ”Ногоон Мандалговь”,”Шинэ гудамж” төслүүдийг хэрэгжүүлнэ.	- Төсөл болон дэд хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх орчин, хотын төвийн ногоон байгууламж нэмэгдэж, гудамж тохижсон байна.	Гоёлын 53ш гэрлийг “Мосума корпораци” ХХК –тай хамтран сумын ОНХС-ын 9 сая төгрөгөөр гүйцэтгэлээ. "Ногоон Мандалговь" дэд хөтөлбөрийн хүрээнд 15600 цэцэг, 2 га талбайд 2415 ш мод суулган сургууль, цэцэрлэгүүд гадна талбайдаа 9000 ширхэг мандлын цэцгийг тарьж, 300 ш хайлаас, хуайс, 72 мкв зүлэгжүүлэлт, арчлалт хамгаалалтыг хийж, нийт 17900 мод тарьсан нь 537 сая м3 агаар цэвэрших нөхцлийг бүрдүүллээ.Арвижих багийн 14 гудамжинд 222, Мандал багийн 13 гудамжинд 383, Айраг багийн 5 гудамжинд 164 нарны зайн цэнэглэгчтэй гэрэлтүүлэгчийн зураг, төсөв боловсрууллаа.	70
		6.2.14.Хотын төвийн авто замын зарим уулзваруудад гэрлэн дохио суурилуулна.	- Сургуулийн гудамжны замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдана.	Цаг уур, Жаст ШТС, Бүрдийн уулзварт аймгийн ОНХСангийн 104770896 төгрөгөөр “Сүлжээт зам” ХХК, “Оптик энерги” ХХК гэрлэн дохиог стандартын дагуу хийж гүйцэтгэлээ.	100
Хэрэгжилт- 81.25%					

Нийт хэрэгжилт- 81.59%

САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР